*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# АРВАЙХЭЭР СУМЫН ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ХЭРЛЭНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** “НЭГ. “Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД” | | | | | | | |
| 1. | 1.1.Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх. | Хяналтад авч хэрэгжүүлсэн заалтын хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | МУ-ын ЗГазар болон аймаг, сум орон нутгийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлж ажилласан.<br>Үүнд: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол болон (Иргэний хяналтын багийн ажиллах журам,<br>Нээлттэй Өвөрхангай хөтөлбөр батлах тухай,<br>“Хайрлагдсан хүүхэд" төслийг батлах тухай, "Халуун ам бүл 1" төслийг батлах тухай,)<br>Засаг даргын захирамж (Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай,<br>Сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчдийн тогтоол (Хотын дүрэм батлах тухай, Хотын соёл хөтөлбөр шинэчлэн батлах тухай, “Хотын соёл – Хариуцлагатай иргэн” зорилтот жилийн ажлын төлөвлөгөө батлах тухай,)<br>“Цэвэр агаар” хөтөлбөрийн тухай,<br>Дээрх тогтоол шийдвэр, захирамжийн хүрээнд “Халуун ам бүл”, “Хайрлагдсан хүүхэд” төслүүд албан хаагчаас хамаарахгүй шалтгаанаар хэрэгжиж эхлээгүй ба бусад тогтоол, захирамжийн биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.“Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөр сурталчлах, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 1 | Тус багт 2025 оны 12 сарын 1 байдлаар нийт 12 өрхийн 25 иргэнээс Улаанбаатараас 6 өрхийн 12 иргэн, өөр аймгуудаас 6 өрх 13 иргэн шилжин ирж суурьшсан байна. Шилжин ирж суурьшсан иргэдээс тэтгэврийн насны 3, ажил эрхэлдэг 8, иргэн байна. ЕБС, СӨБосовсролд 11 хүүхдийг хамруулан ажилласан. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 0 | 100 | Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна шилсэн ирсэн иргэдийн хүүхдүүдийг хамран сургах тойргыг ЕБС, СӨБ-д бүрэн хамруулсан. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 1.3. Сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх. | Зарлагдсан ажлын байрны зарыг иргэдэд хүргэсэн тоогоор | 0 | 28 | Сул ажлын байрны зар, мэдээллийг иргэдэд багийн Facebook аккаунт, группчат, хэсгийн ахлагч нараар дамжуулан байнгын болон түр ажлын байранд 28 гаруй иргэнд зар хүргэн ажилласан байна. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | | Ажилд зуучлагдсан иргэдийн тоогоор | 0 | 20 | Байнгын болон нийтийг хамрсан ажил, түр ажлын байранд нийт 20 иргэн харуулсан. Үүнд: түр ажлын байранд 8, нийтийг хамарсан 7, байнгын ажилд 5 иргэнд зар хүргэж ажилд зуучилсан. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 1.4.“Хотын соёл-Хариуцлагатай иргэн” зорилтот жилийн ажлыг багт зохион байгуулах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100 | “Хотын соёл- Хариуцлагатай иргэн" сумын зорилтот жилийн ажлын хүрээнд багт хийгдэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт 12 арга хэмжээний хүрээнд төлөвлөн, төлөвлөгөөг батлуулж ажилласан. Зорилтот жилийн ажлын хүрээнд “Суралцагч хот-Арвайхээр” өдөрлөгт багийн шугаман бүжгийн хамтлаг болон 5 хэсгийн ахлагч, иргэдийг амжилттай хамруулсан. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 1.5.“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 0 | 2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллаж байна.<br>17."Хотын соёл-Хариуцлагатай иргэн” зорилтот жилийн хүрээнд Арвайхээр сумын ахмадын хорооноос “Тохилог хашаа” төслийг хэрэгжүүлэн төслийн хүрээнд агрономич Ё.Энхтуяа 12 дугаар багийн иргэний хашаанд мод цэцэг тарьж ургуулах, | 2025.01.01. 2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үрсэлгээ бэлтгэх талаар иргэдэд заавар зөвлөмж өгч, практик сургалтыг хийв. Сургалтад 21 иргэн хамрагдаж мандлын цэцэг тарих зөвлөмж гарын авлага болон цэцгийн үрсэлгээ, үр өгч хашаандаа цэцгийн мандалтай болох арга зүйгээр хангав.<br>Арвайхээр сумын хотын Захирагчийн албанаас мод, бут тарих сонирхолтой айл өрхүүдэд тодорхой нөхцөлтэйгөөр дэмжлэг үзүүлэхээр хайлаас, агч, монос зэрэг модны суулгацыг өгч Зүлэгт 12 дугаар багийн 12 өрхөд хайлаас 82 ширхэг, монос 10 ширхэг, агч 23 ширхэг нийт 115 модыг гэрээ байгуулан хуваарилан, мод тарих зааварчилгааг өгөв. Мөн нэмэлтээр 2025 оны 10 дугаар сард буюу намрын мод тарилтаар хотын Захирагчийн албанаас 50 ширхэг хайлаас модыг баг тус бүрд өгч, Зүлэгт 12 дугаар баг 50 ширхэг хайлаас модыг 5 өрхөд хуваарилан мод тарих зааварчилгаа өгч ажилласан.<br>Энэ онд шинээр багийн 23 өрх, 197 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлсэн байна. | | |
| | | Ногоон байгууламж нэмэгдүүлсэн өрхийн хувиар | 10 | 18 | Энэ онд багийн 40 өрх иргэн, 221 ширхэг мод бут тарьсан мэдээтэй байна. Энэ нь багийн нийт өрхийн 8 хувийг эзлэж байна. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | | Нийтийн эзэмшлийн зам талбайнд тарьсан модны тоогоор | | 50 | 12 дугаар багийн шугаман бүжгийн "Айзам" хамтлагийн ахмадууд дайргийн голд чацаргана, монос, өрөл зэрэг жимсний мод тарьж, 12 дугаар багийн ахмадуудын жимсний төгөлтэй болов. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 1.6.Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 3 | 3 | 2025 онд бүх нийтийн их цэвэрлэгээг 3 удаа зохион байгуулж, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүллээ. Цэвэрлэгээнд нийт 87 өрхийн төлөөлөл 104 иргэн их цэвэрлэгээнд хамрагдан, 15 тонн хогийг хогийн цэгт төвлөрүүлсэн. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ачилтад хяналт тавих | Хог хаягдал ангилан ялгах савтай болсон өрхийн тоогоор | 9 | 12 | Айл өрхүүдэд ахуйн хог хаягдлаа ангилан ялгах сурталчилгааг тогтмол хийж байгаагийн зэрэгцээ 12 өрх хогоо ангилан ялгаж хэвшсэн байна. | 2025.01.01.<br>2025.12.01. | 70 |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоогоор | -- | 30 | Багийн их цэвэрлэгээнд хамрагдсан 33 иргэнд хогоо хэрхэн ангилан ялгах талаар мэдээлэл өгч граын авлага тарааж 1 удаагийн их цэвэрлэгээг хогоо эх үүсгэвэр дээр нь ангилан ялгаж цэвэрлэсэн.<br>Арвайхээр хотын Захирагчийн албанаас санаачлан "Хог хаягдлын менежментийг сайжруулах" сэдэвт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж Зүлэгт 12 дугаар багийн 2 хэсгийн ахлагч хамрагдсан.<br>Мөн "Монгол орноо хоггүй болгоё" сэдэвт сургалтанд багийн 5 иргэн хамрагдсан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 1.7.Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж, байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах. | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн хувиар | 1 | 1 | Энэ онд ажил нь эхлээгүй хэрэгжээгүй болно. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | | Сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор | 10 | 25 | Энэ жилийн байдлаар 15 өрх шинээр стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. 12 өрх хуучин нойлоо ариутгаж засварлаж муу усны цооногтой болсон байна | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.8.“Шинэ хоршоо” хөдөлгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор МУЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг талаарх мэдээллийг малчдад сурталчилж, хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, бүрдүүлэх материалыг хагас жилийн мал тооллогоор 16 өрхөд тарааж, мэдээлэл өгч ажилласан | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | | Хоршоонд хамрагдсан малчдын хувиар | 12 | 15 | МУЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг талаарх мэдээллийг малчдад сурталчилж, хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, бүрдүүлэх зэрэг заавар зөвөлгөөг өгч ажиллаа. Багийн 16 малчин өрх 2 хоршоонд хамрагдсан. Хоршоо хөгжүүлэх сангаас 1 хоршоо зээл авч үйл ажиллагаа нь эхлээд байна. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 1.9. Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Багийн нутаг дэвсгэрт болон иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор 12 заалт бүхий төлөвлөгөөг сумын Засаг даргын орлогчоор батлуулж 100 хувийн үр дүнтэй хэрэгжүүлээд байна. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 1.10.Төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах, иргэдэд мэдээлэл хүргэх | Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоогоор | 3 | 5 | Бизнэс эрхлэгч Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан төсөл бичих аргачлалд багийн 3 эмэгтэй хамрагдав.<br>ХХҮГазраас зарласан Хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд зориулсан төсөл хөтөлбөрт багийн 5 иргэн, малжуулах төсөл хөтөлбөр 1,<br>нийт 6 иргэн төсөл өгч дэмжигдсэн. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| **Зорилт 2.** “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД” | | | | | | | |
| 2. | 2.1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | ЗГ-ын 2017 оны 67 дугаар тогтоол, 2011 оны 339, 340-р тогтоолын дагуу 03 сарын 28-ны өдрийн 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага сургуульд багийн | 2025.01.01. 2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг ханган ажиллах.. | | | | иргэд багийн Нэгдсэн төвийн гадна талбайд цуглаж 38 иргэн жагсаж, дүн мэдээг ОБГ-т дамжуулсан. Иргэдэд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх материал тарааж, Онцгой байдлаас иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Мөн багийн facebook хуудсанд Бэлэн бай зөвлөмж, цугларах байршлын пост оруулсан. 2025 оны 10 сарын өдөр ОБГазараас төлөвлөгөөт бэлэн байдлын үзлэгт багийн 5 сайн дурын иргэнтэй оролцсон. | | |
| | 2.2.Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах. | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүнд элсүүлсэн иргэний тоогоор | 5 | 5 | Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмайн хороотой хамтран ажиллаж улаан загалмайгаас газар хөдлөлтийн бэлэн байдал, анхны тусламж, чиглэлээр зохион байгуулсан 1 өдрийн сургалтанд хамрагдсан. Улаан загалмайн гишүүнээр 3 ахмад 3 иргэн хамруулан ажиллаа. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 2.3.Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 87 | 100 | Харьяа "Уян сэтгэл" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувьтай. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | | Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 22 | 30 | Багт 488 өрхийн 1706 иргэн байна. 18-60 насны 855 иргэн байгаагаас эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 44 иргэнийг хамруулсан. Энэ насны иргэдээс 5 хувь нь эрт илрүүлэгт хамрагдах хүсэлт ирж БОЭТөвд үзлэг шинжилгээнд хамруулсан.<br>18-аас дээш насны 991 иргэн байгаагаас "Уянсэтгэл" ӨЭМТөвд урьдчилан сэргийлэх үзлэгт чихрийн шижин 413, артерийн даралт 604, хөх 351, элэгний хорт хавдар 184, умайн хүзүүний хавдарын эрт илрүүлэгт 124 иргэд хамрагдсан.<br>2.Уянсэтгэл ӨЭМТөв нь БОЭТөвтэй хамтран нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эхо үзлэг зохион байгуулсан.Үзлэгт 36 эмэгтэй хамрагдсан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 2.4.Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувь | 80 | 100 | Баг хариуцсан малын эмч Батзаяатай гэрээ байгуулан малын вакцин туулганд цаг тухай бүрд нь оруулан ажилласан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.5.Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах. | Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар | 100 | 100 | Хагас жилийн түүвэр судалгаанд 12 өрх сонгогдон ирж мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулан ажилласан. Жилийн эцсийн малчин, мал бүхий 80 гаруй өрхийн мал тооллогын ажлыг алдаагүй үнэн зөв оруулан ажиллана. | 2025.01.01. 2025.06.15. | 100 |
| | 2.6.“Багийн хамтарсан баг”-ийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Хамтарсан баг 2025 оны төлөвлөгөөг 5 зорилт 16 арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөг батлуулан эхний хуралдаанаар төлөвлөгөөг танилцуулж нууцын гэрээ байгуулав. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хэрэгжиж ажиллаа. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | | Хамтарсан багийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | Энэ онд нийтдээ 7 кейс дээр ажилласан. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 4 дуудлага, хүүхэд хамгааллын хамтарсан багаар илрүүлсэн 3. Үүнээс 6 кейсийг хааж кейс шийдвэрлэлтийн хувь 100 хувьтай байна. 7 өрхийн 11 хүүхдэд хариу арга хэмжээ авч ажилласан | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 2.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 92 | 100 | Багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт, 12 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж, багийн ИНХ-ын Зөвлөлөөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 4 | 4 | Багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтыг сард 2 удаа тогтмол хийж үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, болон багийн эрсдэлт бүлгийн айл өрх, архины хамааралтай иргэдээр тогтмол эргүүл хяналт хийн ажилласан.<br>Багийн ажлын албанаас ”Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хүүхдээ цахим хэрэглээнээс татгалзах урьдчилан сэргийлэх, хамгаалах нөлөөллийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд багийн 35 иргэнийг хамруулсан.<br>Багийн ажлын албаараа согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой зөрчил, эрүүгийн | 2025.01.01. 2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцлагад оногдуулах ялын бодлогыг чангатгасан постер бэлтгэн 3 усан сан, 5 хүнсний дэлгүүр, тоглоомын талбай, 4 автобусны буудалд болон багийн групт байршуулж сурталчилан ажилласан.<br>Өвөрхангай аймгийн Политехникийн коллежийн оюутнуудын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, өөрийгөө болон бусдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвартай болгох, сургуулийн орчинд аюулгүй, ээрэг, хариуцлагатай харилцааг төлөвшүүлэх зорилгоор “Хууль-Миний хамгаалалт” сэдэвт нөлөөллийн сургалтыг Арвайхээр сумын Зүлэгт 12 дугаар багийн хамтарсан баг зохион байгуулав. Политехникийн коллежийн нэгдүгээр курсийн 103 оюутан хамрагдсан байна. Хамтарсан багийн үүрэг оролцоо түүнтэй холбогдох мэдээллийг гарын авлагаар бэлтгэн тараасан. | | |
| | 2.8.Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх | Мэдээний тоо | 47 | 47 | Статистикийн хугацаатай мэдээ тайлан болох Төл бойжилт, том мал, төл малын зүй бус хорогдлын мэдээ, ХАА-н программ, Мал тооллогын хугацаатай мэдээ тайланг сум хариуцсан мэргэжилтэнд цаг хугацаанд нь бүрэн өгч, программд шивж оруулсан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 2.9.Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар | 95 | 100 | Багийн Засаг дарга нь зохион байгуулагч, нийгмийн ажилтныг өдөр тутмын удирдлагаар хангаж, хувийн зохион байгуулалт, сахилга, дэг журам, ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, иргэний хүссэн мэдээлэлд тулгуурлан үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байна. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 2.10.БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг | Зохион байгуулсан хурлын тоо | 4 | 3 | БИНХурал 3 удаа болж хуралд Аймаг сумын удирдлагууд болон багийн 289 иргэн оролцлоо. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

Чурт дааловрал хүргэ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах | | | | Нийт 289 иргэн хуралд оролцож, үүнээс залуучууд хуралд оролцсон иргэдийн 30.1 хувь нь байна. | | |
| | | Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | Хурлаар БИНХ-ын хуралдааны дарга болон БИНХ-ын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгож, “Зөвлөлийн ажиллах журам”-ыг баталлаа. 2026 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийх ажлын санал авлаа. Иргэдээс гаргасан санал хүсэлтийг Арвайхээр сумын Засаг дарга, түүний Тамгын газар, Хотын Захирагчийн албанд уламжилсан. 2026 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналд багийн сонгуулийн насны 982 иргэнээс цаасан маягтаар 175 иргэн буюу 17.8 хувь нь санал өгсөн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад багийн сонгуулын насны иргэдийн тоо 56 хувиар, цаасан маягтаар санал өгсөн иргэдийн тоо 11 хувиар буюу 0.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн тулгамдаад байгаа томоохон асуудлын нэг болох үерийн ус зайлуулах далан шуудууны ажлыг Төлөөлөгчийн хувиар анхаарал хандуулж шийдвэрлэж өгөхийг аймгийн ИТХурлын төлөөлөгч Д.Амартүвшинд уламжилсан. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 2.11.Төр болон хувийн аж ахуйн нэгж байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх | Хүртээмжийг нэмэгдүүлсэн байгууллага аж ахуйн нэгжийн тоогоор | - | 4 | Энэ онд хамтран ажилласан байгууллага Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэг, ЕБ-ын 4 дүгээр сургууль, Политехник коллежи, ХГБХХГазар, Цагдаагын газар, мөн багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан байна. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 2.12.Багийн нутаг дэвсгэр дэх Түүх соёлын дурсгалт газар, эд зүйлийн хамгаалалтыг сайжруулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 1 | Багийн нутаг дэвсгэр дэх Түүх соёлын дурсгалт газар, одоогоор бүртгэгдээгүй байна. | 2025.01.01. 2025.12.01. | 100 |
| | 2.13.Эзэнгүй муур нохойн тоо толгойг цөөрүүлэх, эзэнтэй | Зохион байгуулсан | - | 1 | 2025 онд Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар 2,3,4,5,7,10 дугаар саруудад нийт 13 удаагийн нохой устгалын ажлыг хийж, Зүлэгт 12 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | муур нохойн бүртгэлжүүлэх | арга хэмжээний тоогоор | | | дугаар багийн ажлын алба тус байгууллагатай хамтран ажиллаж эзэнгүй 20 нохойг устгалд оруулсан. | | |
| | | Муур, нохойг бүртгэлжүүлж, вакцинд хамруулах хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | - | 1 | Өвөрхангай аймгийн мал эмнэлгийн газрын Арвайхээр сум дахь мал эмнэлгийн тасгийн даргаас мал амьтны галзуу өвчин нь мал, амьтнаас хүнд халдварладаг учраас гарах эрсдэлээс хамгаалж, улсын хэмжээнд бүх нохойг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулах тул төвлөрсөн суурин өрхийн нохойны тооллого мэдээлэл, судалгааг ирүүлэх албан бичгийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр багийн 115 эзэнтэй нохойны судалгааг хавсралт маягтын дагуу гаргаж, мал эмнэлгийн тасагт хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Арвайхээр хотын Захирагчийн албаны эрүүл ахуй, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэнд багийн эзэнтэй нийт 119 нохойны судалгааг тус тус хүргүүлсэн. | 2025.01.01.<br>2025.12.01. | 70 |
| | | Үржил хязгаарлах иргэдийн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | - | 100 | Энэ оны 11 дүгээр сарын байдлаар нохой, муурны үржил хязгаарлах талаар иргэдээс хүсэлт ирүүлээгүй ба 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар иргэдээс нохой устгах, айл өрхүүд нохойгоо уяхгүй байна зэрэг нийт 9 гомдол, мэдээлэл ирүүлснийг 100 хувь шийдвэрлэж ажилласан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 Хаеах |
| **ГУРАВ. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"** | | | | | | | |
| 3. | 3.1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврын хэрэгжилт хувь | 100 | 100 | Байгууллагын шуурхай хурал болон бусад цаг үеийн хуралд тогтмол оролцож, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллалаа. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 3.2.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Иргэдээс 1,2,3,4 дүгээр улиралд мэдэгдэл 1 буюу хүүхдээ хүчээр морь унуулаад байна гэх 1, болон | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх | | | | нийт 55 өргөдөл, гомдол ирүүлсэн гомдлыг 100 шийдвэрлэж, авсан хариу арга хэмжээг гомдол гаргагч иргэдэд биечлэн болон цахимаар хүргэж ажилласан.<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо 23-аар өссөн үзүүлэлттэй байгаа нь иргэдийн өргөдөл, гомдлыг цаг алдалгүй хүлээн авч, шийдвэрлүүлсэний үр дүн юм. | | |
| | | Emolgolia-д ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 100 | 100 | Emolgolia-д ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар 100 хувь шийдвэрлэн ажилласан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| **ДӨРӨВ. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 4. | 4.1.Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх. | Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | Арвайхээр сумын Зүлэгт 12 дугаар багийн ажлын албанд 2025 онд нийт 93 албан бичиг ирснийг бичгийн дэвтэрт бүртгэж хэвшсэн. Үүнээс хугацаатай албан бичгийн хариуг хүргүүлсэн байдлаар: Өвөрхангай аймгийн ЗДТГазар 1, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газарт 9, ХХҮГ 8, ШШГГ 1, Өвөрхангай аймаг дахь мал эмнэлгийн тасагт 1, болон бусад байгууллагаас 18, зэргийг албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулан заасан хугацаанд хүргүүлж, бүртгэлээр тавих хяналтыг хэвшүүлсэн. Хугацаатай үүрэг даалгавар, судалгаа, тайлан мэдээг товлосон хугацаанд хүргүүлэн ажиллаж, тайлан мэдээг хоцроосон зөрчилгүй ажиллаж байна. | | 100 |
| | | Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | Мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар гаргаж, мөн цаг үеийн шаардлагаар нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.2.Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх. | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | 100 | 100 | Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаарх мэдлэг, мэдээллээ байнга дээшлүүлж, ашиг сонирхлын зөрчил үүсгэлгүй албан тушаалын чиг үүргээ үнэнч шударгаар биелүүллээ.<br>Байгууллагын “Дотоод журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ард түмэн, олон нийтэд үйлчлэх явдлыг өөрийн эрхэм үүргээ гэж үзэн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийлгэлгүй шударгаар ажиллалаа. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | | Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар | 100 | 100 | Ажлын шаардлага болон ачааллаас хамаарч өдөрт 10-аас доошгүй цагаар ажиллаж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар 51 илүү цаг болон шөнийн цагаар ажиллаж, нэг удаа ажил таслаагүй, хоцроогүй байна.<br>Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэх зөрчил гаргалгүй, хариуцсан ажлын чиглэлээр аймгийн МШУТөвийн утсаар нэр заасан гомдол гаргалгүй ажиллалаа. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 4.3.Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох | Хамрагдсан хувиар | 100 | 100 | Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцож байгууллагын албан хаагчдын дунд 2 даа тэмцээн уралдаан зохион байгуулсан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 4.4.Байгууллагаас зохион байгуулсан сургалт, судалгаанд хамрагдсан тоогоор | Хамрагдсан арга хэмжээний хувиар | 100 | 100 | Байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, зохион байгуулсан сургалт судалгаанд бүрэн хамрагдсан | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |
| | 4.5.Байгууллага, багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах | Арга хэмжээний тоогоор | - | - | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан "Хайр түгээе-Инээд бэлэглэе" арга хэмжээ зохион байгуулж хандиваар цугласан 70 ширхэг бэлгийг зорилтот бүлгийн 70 хүүхдэд өгсөн.<br>2.Хүүхдүүдийн дунд сагс, волейболлын тэмцээн зохион байгуулж зааланд үнэ төлбөргүй 30 хүүхэд тоглуулсан. | 2025.01.01.<br>2025.12.01. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.Арвайхээр сумын улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэг багш тус цэцэрлэгийн урлаг зааланд эцэг, эхчүүдийг хүлээн авч "Гэр бүлийн үнэ цэнэ" сургалт зохион байгуулж нийт 53 асран хамгаалагчдыг хамруулсан. | | |

| Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт | | | | |
|---|---|---|---|---|
| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Багийн ахмадын өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах | Ахмадуудыг итэвхжүүлэх, хамруулсан ахмадын тоогоор | 1.Ахмад настан 167 өрхийн, 138 ахмад байгаагаас байгууллагын харъяалалгүй 120 ахмад байна. "Ахмадаас суралцахуй" "Баясах өдөр" арга хэмжээ зохион байгуулж 142 оролцсоноос 45 ахмад 12 дугаар багаас оролцсон.<br>2.Багийн ахмадууд "Урлагийн наадам-2025", "Суралцагч хот Арвайхээр" өдөрлөг зэрэг арга хэмжээнд 28 ахмад оролцлоо.<br>3."Хотын соёл-Хариуцлагатай иргэн" зорилтот жилийн хүрээнд Арвайхээр сумын ахмадын хорооноос "Тохилог хашаа" төслийг хэрэгжүүлэн төслийн хүрээнд агрономич Ё.Энхтуяа 12 дугаар багийн иргэний хашаанд мод цэцэг тарьж ургуулах, үрсэлгээ бэлтгэх талаар иргэдэд заавар зөвлөмж өгч, практик сургалтыг хийв.<br>2025 оны 10 дугаар сарын 26-ны өдөр **Зүлэгт** 12 дугаар багийн ажлын алба, багийн ахмадын даргатай хамтран "Ахмадын өдөрлөг"-ийг "Баянтүмэн" амралтын газарт зохион байгуулсан. Тус ахмадын өдөрлөгийг аймгийн ИТХ-ын 12 дугаар багийн тойргийн төлөөлөгч Д.Амартүвшин, сумын ИТХ-ын 12 дугаар багийн тойргийн төлөөлөгч Ч.Доржбат, багийн Засаг дарга Б.Хэрлэн нар ивээн тэтгэж багийн ахмадуудаа баярлуулсан. Ахмадын өдөрлөгт нийт 98 ахмад оролцсон. Энэхүү арга хэмжээний хүрээнд ахмадуудын дунд дуу, хөзөр, даалуу зэрэг тоглоомын тэмцээн зохион байгуулахаас гадна багийн ахмадын "Айзам" хамтлаг шугаман бүжигээр мэндчилгээ дэвшүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Багт хуваарьлагдсан өвс тэжээлийг малчидад тараан ажиллах | Малчидад хуваарьлагдсан тэжээлийг бүрэн тараасан байх | Тус онд малчидад хөнгөлөлттэй үнээр тараасан өвс 100, ногоон тэжээл 100, Баавар тэжээл 14, тус тус багийн малчидад хуваарьлан тараан ажиллаа. | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан шинэлэг арга хэмжээ зохион байгуулах. Хүүхэд эцэг эх, асран хамгаалагч нарт гэр бүл, хүүхдийн хүмүүжлийн талаар сургалтанд хамруулах | Арга хэмжээ зохион байгуулах, хамрагдсан иргэд хүүхдийн тоогоор | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зүлэгт 12 дугаар багийн ажлын албанаас санаачлан "Хайр түгээе-инээд бэлэглэе" арга хэмжээ 2025.05.31-ний өдөр 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээний хүрээнд нийт 70 хүүхдэд бэлэг өгч 14:00-18:00 цаг хүртэл хүүхдүүдийн дунд сагс, волейболлын тэмцээн зохион байгуулж зааланд үнэгүй тоглуууллаа.<br>Мөн арвайхээр сумын улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэг багш тус цэцэрлэгийн урлаг зааланд эцэг, эх, хүүхэд багачуудыг хүлээн авч "гэр бүлийн үнэ цэнэ" сэдвээр 53 эцэг эх асран хамгаалагч нар сургалт хийв. | 100 |
| | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4 Багийн ажлын албанаас санаачлан Цагдаагийн газар болон Политехник коллежи, ХГБХХГазартай хамтран “Хууль- Миний хамгаалалт” сургалт зохион байгуулсан | Арга хэмжээ зохион байгуулах, хамрагдсан иргэд хүүхдийн тоогоор | Сургалт нь найз нөхдийн нөлөө, сэтгэл зүйн дэмжлэг, суралцагчдын эрх зүйн үндсэн ойлголтыг нэмэгдүүлж, зөрчил болон гэмт хэргийн ялгааг ойлгож аливаа гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, хамт олонч хандлагатай, зөрэг харилцаа төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн сургалт байв.Сургалтад 1 дүгээр дамжааны 15-18 насны 103 суралцагч оролцсон. | 100 |
| | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5 “Арвагар хээр-Horse festival” адууны баяр зохион байгуулах | Ажлын хэсэгт орж хариуцлагатай ажилласан байх | “Арвагар хээр-Horse festival” адууны баяр Монгол түмний морины их шүтээн цогцолборт болсон. Адуучин тэмцээн хариуцан зохион байгуулалтанд оролцсон. | 100 |

**ХОЁР. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | А3 Сертифизаттай сургалтанд хамрагдах | Сертификат | - | Цахимаар болон | Хэрэгжих хугацаа болоогүй | I-IV улиралд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биечлэн судлах | | | |
| 2 | “Удирдлагын академи”-ийн “Мэдээллийн аюулгүй байдал” сургалтад хамрагдах | Сертификат | - | 10 цаг | Мэдээллийн аюулгүй байдал, байгууллагын удирдлагын систем ашиглах сэдэвт сургалтад багийн ажлын алба хамрагдсан.<br>Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдыг ажлын байрандаа суралцах, хөгжих боломжоор хангаж, төрийн албан хаагчийн сургалтын нэгдсэн платформд байршуулсан мэдээллийн технологийн чиглэлийн 14 төрлийн цахим хичээлийг судалсан. | I-IV улиралд | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН

ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА ................................ Б.ХЭРЛЭН 2025.12.01
(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)

**ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА БАЯРТОГТОХЫН ХЭРЛЭНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Арвайхээр сумын ЗДТГазар
Нэгжийн нэр: Арвайхээр 12 дугаар багийн ажлын алба

**1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллах** | | | | | |
| 1 | Арга хэмжээ №1.1.1 | 47 | 10 | 57 | 57 |
| 2 | Арга хэмжээ №1.2.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 3 | Арга хэмжээ №1.2.2 | — | — | 0 | 0 |
| 4 | Арга хэмжээ №1.3.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 5 | Арга хэмжээ №1.3.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 6 | Арга хэмжээ №1.4.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 7 | Арга хэмжээ №1.5.1 | 30 | 10 | 40 | 40 |
| 8 | Арга хэмжээ №1.5.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 9 | Арга хэмжээ №1.5.3 | 30 | 10 | 40 | 40 |
| 10 | Арга хэмжээ №1.6.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 11 | Арга хэмжээ №1.6.2 | 30 | 10 | 40 | 40 |
| 12 | Арга хэмжээ №1.6.3 | 60 | 10 | 70 | 70 |
| 13 | Арга хэмжээ №1.7.1 | | Хасах | | — |
| 14 | Арга хэмжээ №1.7.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 15 | Арга хэмжээ №1.8.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 16 | Арга хэмжээ №1.8.2 | 47 | 10 | 57 | 57 |
| 17 | Арга хэмжээ №1.9.1 | 56 | 10 | 66 | 66 |
| 18 | Арга хэмжээ №1.10.1 | 60 | 10 | | 70 |
| **Зорилт 2. Багийн өрх, хүн амын статистикийн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах** | | | | | |
| 20 | Арга хэмжээ №2.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 21 | Арга хэмжээ №2.2.1 | 47 | 10 | 57 | 57 |

10 + 60 = 70
70 - 100
40 - x

3

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | Арга хэмжээ №2.3.1 | | | 70 | 70 |
| 23 | Арга хэмжээ №2.3.2 | | | 70 | 70 |
| 24 | Арга хэмжээ №2.4.1 | | | 70 | 70 |
| 25 | Арга хэмжээ №2.5.1 | | | 70 | 70 |
| 26 | Арга хэмжээ №2.6.1 | | | 70 | 70 |
| 27 | Арга хэмжээ №2.6.2 | | | 70 | 70 |
| 28 | Арга хэмжээ №2.7.1 | | | 70 | 70 |
| 29 | Арга хэмжээ №2.7.2 | | | 70 | 70 |
| 30 | Арга хэмжээ №2.8.1 | | | 70 | 70 |
| 31 | Арга хэмжээ №2.9.1 | | | 0 | 0 |
| 32 | Арга хэмжээ №2.10.1 | | | 70 | 70 |
| 33 | Арга хэмжээ №2.10.2 | 21 | 10 | 31 | 31 |
| 34 | Арга хэмжээ №2.11.1 | — | — | 0 | 0 |
| 35 | Арга хэмжээ №2.12.1 | 21 | 10 | 31 | 31 |
| 36 | Арга хэмжээ №2.13.1 | | | 70 | 70 |
| 37 | Арга хэмжээ №2.13.2 | 49 | 10 | 59 | 59 |
| 38 | Арга хэмжээ №2.13.3 | - | хасах | | — |
| **Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | |
| 39 | Арга хэмжээ №3.1.1 | | | 70 | 70 |
| 40 | Арга хэмжээ №3.2.1 | | | 70 | 70 |
| 41 | Арга хэмжээ №3.2.2 | | | 70 | 70 |
| **Зорилт 4. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”** | | | | | |
| 42 | Арга хэмжээ №4.1.1 | 54 | 10 | 64 | 64 |
| 43 | Арга хэмжээ №4.1.2 | | | 70 | 70 |
| 44 | Арга хэмжээ №4.2.1 | | | 70 | 70 |
| 45 | Арга хэмжээ №4.2.2 | | | 70 | 70 |
| 46 | Арга хэмжээ №4.3.1 | | | 70 | 70 |
| 47 | Арга хэмжээ №4.4.1 | | | 70 | 70 |
| 48 | Арга хэмжээ №4.5.1 | | | | 70 |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | | | 70 | 70 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | | | | - |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. | | | 70 | 70 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. | | | | |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. | | | 70 | 70 |
| **Дундаж оноо** | | | | | |

70 100 - 70
30 - x

**2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Арга хэмжээ 1 | 70 | 10,5 | 10,5 |
| 2 | Арга хэмжээ 2 | ~~100~~ 70 | 10,5 | 10,5 |
| **Дундаж оноо** | | | 10,5. | 10,5. |

**3.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарна) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | 7 |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | 7 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | 7 |
| **Дундаж оноо** | | 7 | 7 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (хамт олны үнэлгээ)**

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| **Дундаж оноо** | | |

**5.Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.) | (70 хүртэлх оноо) 59,6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | (15 хүртэлх оноо) 10,5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ) | (7 хүртэлх оноо) 7 |

| | | |
|---|---|---|
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>(Хамт олны үнэлгээ) | (8 хүртэлх оноо)<br>8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) | ( ..... оноо) |
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо. | | 85,1 |

**Үнэлгээ өгсөн:** **Нэгжийн дарга**

...................................... ........................................... /................................../

(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

................................ (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, Зөвшөөрсөн**: **Төрийн жинхэнэ албан хаагч:**

Зүлэгт 12 дугаар багийн Засаг дарга ............................................ / Б.ХЭРЛЭН /

2025.06.13

**Үнэлгээг хянасан:**

Үнэлгээний багийн төлөөлж ахлагч:

ЗДТГын дарга ............................................ /С.Ганчимэг/

(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

................................ (огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

............................................ ............................................ /................................../

(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

................................ (огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:** **Төсвийн шууд захирагч**

Арвайхээр сумын ЗДТГазрын дарга ............................................ / С.ГАНЧИМЭГ /

(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

................................ (огноо)